

МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2023 оны \_\_\_ сар \_\_\_ өдөр

Дугаар \_\_\_

Улаанбаатар хот

Даатгалын багц дүрэмд  
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.3, 6.2.4, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2.1, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 6 дугаар зүйлийн 6.1, 6.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-д доор дурдсан агуулга бүхий 4.6.10, 4.6.11, 7.1.12 дахь заалтыг тус тус нэмсүгэй.

“4.6.10.Банк, түүний салбар, төлөөлөгчийн газар нь даатгалын бүтээгдэхүүн тус бүрийн хувьд 5 буюу түүнээс дээш даатгагчийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зуучилна.”

“4.6.11.Банк нь хамтран ажиллаж буй даатгагчаас бусад даатгагчтай даатгалын гэрээ байгуулах боломжийг өөрийн харилцагчид олгоно.”

“7.1.12.Даатгагч нь банк даатгалын зуучлагчаар дамжуулан зуучлан борлуулах даатгалын бүтээгдэхүүнийг Хороонд тусгайлан бүртгүүлнэ.”

2.Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.3.6, 4.6.7 дахь заалтыг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай.

“4.3.6.Зуучилсан даатгалын гэрээний дэлгэрэнгүй бүртгэлийг тухай бүр хөтөлж, харилцагч, үйлчлүүлэгчийн мэдээллийн сан үүсгэх, даатгалын гэрээ болон даатгуулагчийн талаарх мэдээллийг хамтран ажиллах гэрээнд заасан хугацааны дотор даатгагчид хүргүүлэх;”

“4.6.7.Банк нь даатгагчийн энэ журмын 7.1.12-т заасны дагуу Хороонд бүртгүүлсэн даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг зуучлах бөгөөд даатгалын компанитай байгуулах хамтран ажиллах гэрээнд зуучлан борлуулах даатгалын бүтээгдэхүүнийг тодорхой зааж, тусгасан байх;”

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-д даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН